

**ТГ-ын захирал Г.Цэрэнпүрэв:** Сорьцын зөрүү байсныг Монголбанк илрүүлж, хуулийн байгууллагад хандсан

Монголбанкнаас 18 кг алт алдагдсан гэх дуулиан дэгдээд байгаа. Энэ талаар Монголбанкны Тамгын газрын захирал Г.Цэрэнпүрэв тодруулга өглөө.

**-Монголбанкнаас их хэмжээний алт алдагдсан. Үүнд төв банкны ажилтнууд өөрсдөө холбогдсон гэх мэдээлэл олон нийтийн дунд байна. Алт дутаж байгааг яаж мэдсэн бэ?**

-Монголбанк сорьцийн зөрүүн дээр тодорхой хэмжээний алдагдал хүлээсэн. Үүнийг Монголбанкны Дотоод аудитын газрынхан өөрсдөө илрүүлсэн байгаа. Алт олборлогчдын олборлосон алтыг Стандартчилал, хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын албанд хайлуулдаг. Хайлуулж гулдмай болгосон алтнаас дээж авч сорьц тогтоодог. Сорьцын хяналтын албаны тогтоосон сорьцын бичигтэй алтыг л Монголбанк худалдаж авдаг. Авсан алтаа гадаад руу ачих хүртэл тусгай өрөөнд бичиг баримттай нь хадгалдаг. Гадагшаа ачихад ч тусгай бүрэлдэхүүн ажилладаг. Цэвэршүүлэх ажлыг Монголбанк биш гадаадын тусгай байгууллага хийдэг. Төв банк дамжуулагчийн үүрэг гүйцэтгэдэг шүү дээ.

**-Төв банкнаас алт авсан гадаадын байгууллага гомдол гаргасан юм биш үү?**

-Тийм зүйл байхгүй. Төв банкны Дотоодын аудитын газрынхан гадаадад тушаасан алтнаас сорьцын зөрүү гараад байгааг илрүүлж улмаар Монголбанк цагдаагийн байгууллагад шалгуулахаар хандсан. Үүний дагуу мөрдөн байцаалтын үйл ажиллагаа явуулж байгаа.

**-Сорьцын зөрүү хаана гараад байгааг олон улсын аудитын байгууллага шалгаж тогтоосон гэх мэдээлэл бий. Танай байгууллагаас хөндлөнгийн шинжээчдэд хандсан уу?**

-Гадаадын аудитын байгууллагад энэ талаар хандаагүй. Харин олон улсын жишгийн дагуу гадаадад цэвэршүүлсэн алтны сорьцыг баталгаажуулахаар олон улсын хөндлөнгийн шинжээч байгууллагад хандаж баталгаажуулсан.

**-Стандартчилал, хэмжил зүйн газрын удирдлагууд энэ хэрэгт ямар ч холбогдолгүй гэж байгаа. Стандартчилал, хэмжил зүйн газраас сорьцолсон алтыг цэвэршүүлэхдээ өөр металл хольчихсон байх үндэслэл бий юү?**

-Шалгаж байгаа байгууллага үүнд тайлбар хийх байх. Тус байгууллагын сорьц, гадаадад хийсэн сорьц хоёрын хоорондох зөрүүний асуудал шүү дээ.

**-18 кг алт дутсан гэж байгаа. Гадаадын зах зээлд гаргасан алтнаас 18 кг дутсан уу. Эсвэл Эрдэнэсийн санд байгаа алтнаас 18 кг дутсаныг илрүүлсэн юм уу?**

-Би дээр хэлсэн сорьцын зөрүү. Тэгэхдээ гадаадад ачуулсан алтны сорьцыг олон улсын хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулсныг ч бас хэлсэн.

**-Алтыг төв банкинд цэвэршүүлдэггүй, сорьцын зөрүү гаргах боломжгүй бол танай ажилтан яаж холбогдсон байх вэ?**

-Хуулийн байгууллага үүнд хариулт өгөх учиртай байх. Эрдэнэсийн сангийн нягтлан бодогчийг саатуулж шалгаж байгаа нь үнэн. Түүнээс одоогоор гурван хүнийг саатуулж шалгасан асуудал байхгүй.

**-Тэгвэл төв банк энэ хэрэгт хохирогчоор тогтоогдчихсон байгаа юу?**

-Тиймээ хохирогчийн үүднээс шалгуулахаар хандсан юм.

**-Гандагтэгчинлэн хийдээс Эрдэнэсийн санд нийлүүлсэн үнэт эдлэлээс дутсан. Үүнийг шалгах явцад 18 кг алтны гэх хэргийн сэжүүр олдсон гэх мэдээлэл бий.**

-Гандантэгчинлэн хийдийн тухайд ажлын хэсэг шалгаад манай зүгээс асуудалгүй гэдгийг тогтоочихсон. Дээр үеийн асуудал. Сорьцын зөрүүнээс үүдсэн хохирлын тухайд бид хуулийн байгууллагад хандаж шалгуулж байна. Шалгаж байгаа хэргийн талаар үүнээс илүү тайлбар өгөх боломжгүй.

**-Эрдэнэсийн санг хариуцаж ажилладаг албан тушаалнууддаа хэр хяналт тавьдаг юм бэ?**

-Эрдэнэсийн санг жилд нэг удаа заавал шалгадаг. Шаардлагатай бол түүнээс ч олон шалгана. Эрдэнэсийн сан тусгай хууль журамтай. Үүний дагуу л үйл ажиллагааг явуулдаг.

**-Нэгэнт Монгол Улсаас гадаад зах зээлд гаргасан алт сорьцын зөрүүтэй гарлаа. Энэ хэрээр Монгол Улсын нэр хүнд унах уу. Цаашлаад манайхаас дэлхийн зах зээлд гарах үнэт метал борлогдохгүй байх эрсдэл бий юү?**

- Эрсдэл байхгүй. Хоёр байгууллагын хооронд хийсэн гэрээг жил бүр дүгнэдэг. Гэрээний заалт зөрчсөн зүйл одоогоор байхгүй.

Б.Цэцэгдэлгэр